



**НИЙСЛЭЛИЙН СҮХБААТАР ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2020 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

Дүүргийн 2019 оны төсвийн гүйцэтгэл  
батлах тухай.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 "б", Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.3 дахь хэсгийг тус тус үндэслэн Сүхбаатар дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас **ТОГТООХ** нь:

1. Дүүргийн 2019 оны орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлийг 73 тэр бум 51 сая 706,6 мянган төгрөгөөр, зарлагын гүйцэтгэлийг 27 тэр бум 674 сая 38,5 мянган төгрөгөөр, Нийслэлд төвлөрүүлэх орлогын гүйцэтгэлийг 35 тэр бум 618 сая 923,0 мянган төгрөгөөр тус тус баталсугай.

2. Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн орлогын гүйцэтгэлийг 580 сая 068,5 мянган төгрөгөөр, зарлагын гүйцэтгэлийг 580 сая 068,5 мянган төгрөгөөр тус тус баталсугай.

3. Дүүргийн тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжигддэг төсвийн байгууллагуудын 2019 оны санхүүжилтийн орлогын гүйцэтгэлийг 47 тэр бум 874 сая 42,0 мянган төгрөгөөр, өөрийн орлогын гүйцэтгэлийг 12 тэр бум 456 сая 158,8 мянган төгрөгөөр, зарлагын гүйцэтгэлийг 61 тэр бум 792 сая 95,9 мянган төгрөгөөр тус тус баталсугай.

ДАРГА  Б.ЭНХБОЛД



1140100038